

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

1. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
..... гэдэг нь нийгэмшилтэд нөлөөлж буй хувь хүн, бүлэг, байгууллага, нийгмийн тодорхой нөхцөлүүдийн цогцыг хэлнэ.

- A. Нийгэмшилтийн агент
B. Конформист
C. Нийгэмшилт
D. Нийгэмшилтийн адилсал

2. Улс төрийн институтын үүрэгт хамаарах ойлголтуудыг сонгоно уу. /1 оноо/

- | | |
|---|-----------------------------|
| 1. Үл мэдэх ба мэдэж болохгүй зүйлст хариулт өгөх | 2. Шинэ мэдлэг бүтээх |
| 3. Бүлэг болон нийгмийг зохицуулах | 4. Боловсон хүчнийг бэлтгэх |
| 5. Нийгмийн дэг журам, аюулгүй байдлыг хангах | 6. Нийтлэг асуудлыг шийдэх |

- A. 2, 5, 6
B. 1, 3, 5
C. 3, 4, 5
D. 3, 5, 6

3. Дараах хүснэгтээс “Хувийн жин” гэсэн тодорхойлолт болон жишээг олно уу. /2 оноо/

Хүснэгт-а		Хүснэгт-б	
1	Сонгогдсон нэг шинж бүхий тохиолдлын тоог нийт тохиолдлын тоонд харьцуулсныг хэлнэ.	1	Нийт гэмт хэргийн тоо 24857. Үүнээс эмэгтэйчүүд 3782 гэмт хэргийг нь эзэлж байна. Энэхүү харьцааг 100-аар үржүүлэх замаар тооцдог. Өөрөөр хэлбэл $\frac{3782}{24857} = 0.15$; $0.15 \times 100 = 15\%$ байна.
2	Пропорцыг 100-аар үржүүлэх замаар тооцдог үзүүлэлт	2	Нийт гэмт хэргийн тоо 24857. Үүнээс нь эмэгтэйчүүд нь 3782 гэмт хэргийг нь эзэлж байна. Өөрөөр хэлбэл $\frac{3782}{24857} = 0.15$ байна.
3	Тодорхой тохиолдол хэдэн удаа илэрч буйг тоогоор илэрхийлэхийг хэлнэ.	3	Эмэгтэйчүүдийн үйлдсэн гэмт хэргийн тоог нийт гэмт хэргийн тоонд хуваах замаар тооцно.

- A. a-3, b-1
B. a-1, b-2
C. a-3, b-3
D. a-2, b-1

4. Мэдээлэл цуглуулах аргуудыг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу. /3 оноо/

а) Туршилт б) Контент анализ в) Баримт бичгийн чанарын шинжилгээ	1	Баримт бичгээс тодорхой утгын нэгжийг хувьсагчаар сонгон, давтамж, хоорондын хамаарлыг статистик шинжилгээ ашиглан шинжлэх арга.
	2	Сонирхож буй хувьсагч хоорондын хамаарлыг илрүүлэхээр зохиомол орчин бүрдүүлэх замаар судлах арга
	3	Тодорхой сэдэв, асуудлыг бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх замаар мэдээлэл цуглуулах арга юм.
	4	Судалгаанд оролцогчдын зан үйл, үйлдэл, зан төлөв, үг яриа, хөдөлгөөн зэргийн талаар тэмдэглэл хөтлөх замаар мэдээлэл цуглуулах арга.
	5	Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран судлах боломжийг олгодгоороо давуу талтай.

- A. а3, в5, с1 B. а2, в5, с1 C. а2, в1, с5 D. а3, в4, с5

5. Бусад үндэстнээс ялгарч буй хэв шинж, өвөрмөц эрхэм гэсэн бүхнээрээ үндэстэн бахархдаг бас эвлэлдэн нягтарч байдаг учиртай. Монгол үндэсний соёлын өвөрмөц шинж, түүний хэрэглээ, үнэ цэн нь, тухайлбал “Би монгол хүн” гэх мэтээр бахархах үндэс суурь болдог. Энэ нь дараах ойлголтуудын алийг илэрхийлж байна вэ? /1 оноо/

- A. Соёлын түгээмэл шинж
 B. Соёлын нэвчилт
 C. Соёлын релятивизм хандлага
 D. Соёлын нэгдмэл шинж

6. “Үнэлгээ” гэсэн ойлголтод хамаарах утга санааг олоорой. /1 оноо/

- A. Нийгмийн бүлэг, бие хүний зан төлөв, үйлдлийг тодорхой шалгуурт нийцэж байна уу, үгүй юу гэдгийг шүүн тунгаах үйл явц.
 B. Хүмүүс үзэл санаа, итгэл үнэмшил, өөрийн тодорхой байр суурь, ёс суртахууны хувьд харилцан адилгүй сонголт хийх үйл явц.
 C. Нийгэмд үйлчилж байдаг хэм хэмжээг эзэмшсэнээр хүмүүс амьдралын чиг баримжаагаа олж авдаг.
 D. Аливаа зүйлийн үнэн эсэхийг шалган тодорхойлох тусгах арга, аргачлал зарчимд тулгуурладаг.

7. Өнөө үеийн соёлын бодлого олон улсын хэмжээнд дараах нийтлэг чиглэлүүдтэй байдаг. Үүнээс илүүц зүйл дурдсаныг олоорой. /2 оноо/

- A. Соёлын зорилго, хөгжлийн хандлагыг хүний хөгжилд чиглүүлэх
 B. Үндэстэн, ястны соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах
 C. Соёлын үйл ажиллагаанд хүн бүрийн оролцох бололцоог хангах
 D. Үндэсний хэлийг сахин хамгаалахгүй шаардлагын тухай сурталчлах

8. Дараах тохиолдлыг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй. /2 оноо/

Бэк-Хён, Чан-Ёол, Ха-Кун, Ин-Су, Кижэ, Минжүн нар солонгос улсаас монгол улсыг зорин аялахаар иржээ. Энэхүү аялал нь зүгээр ч нэг аялал биш харин монгол улсын соёл, түүний үүсэл хөгжил болон соёлын үйлдвэрлэлийн тухай судлахаар ирсэн соёл судлаачид юм. Мэдээж Бэк-Хён, Чан-Ёол, Ха-Кун, Ин-Су, Кижэ, Минжүн нар монгол улсаар аялахдаа монгол улсын соёлын тухай мэдээлэл цуглуулж судалгаа хийх тус тусын чиг үүрэгтэй ирсэн билээ. Тухайлбал:

- Бэк-Хён бол монгол хүмүүсийн зан төлөв, зан чанар болон шашны тухай,
- Чан-Ёол бол олон улсын соёл, барууны соёл, монголын соёлын тухай,
- Ха-Кун бол монголын социализмын үеийн соёлын тухай,
- Ин-Су бол монголын соёлын эртний, дундад зуун, орчин үеийн соёлын тухай,
- Кижэ бол монголын соёлын статик, динамик үзэгдлийн тухай,
- Минжүн бол монголын оюуны болон биет соёлын тухай тус тус судлахаар болжээ.

Асуулт: Солонгосын соёл судлаачдын тус бүрийн чиг үүрэг нь соёлын ямар шалгуурыг илэрхийлж байгааг зөв харгалзуулна уу?

а) Соёлын нийгмийн хэв маягийн тухай б) Соёлын бүтээгч, хэрэглэгчийн тухай в) Соёлын суурь үнэлэмжүүдийн тухай д) Хүмүүсийн сонголт хийх боломжийн тухай	1	Судлаач Бэк-Хён
	2	Судлаач Чан-Ёол
	3	Судлаач Ха-Кун
	4	Судлаач Ин-Су
	5	Судлаач Кижэ
	6	Судлаач Минжүн

A. a4b2c1d3

B. a4b5c1d6

C. a2b5c1d3

D. a2b6c1d4

9. Цогио инфляц аль нь вэ? /1 оноо/

A. 110.9%

B. 99.9%

C. 9.3%

D. 3.1%

10. Хөрөнгийн зах зээлийн өөрчлөлт хөдөлгөөнийг хоёр амьтны ерөнхий шинж чанартай нь адилтгадаг. Тэгвэл зах зээл дэх хөрөнгө оруулагч нар хувьцаагаа зарах нь ихсэж нийлүүлэлтийг нэмэгдүүлснээр хувьцааны үнэ буурахыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

A. Bull market

B. Bear market

C. Tiger market

D. Wolf market

11. Мэдээллийг ашиглан дотоодын нийт бүтээгдэхүүний хэрэглэгчийн зардал, орлогын төрлийг тэмдэглэгээтэй нь тохируулж, орлого болон зардлаар ялгаж тооцоолоорой. /2 оноо/

Тэмдэглэгээ	ДНБ-ний бүтэц
а) I	1) Ажилчдын цалингийн орлого 35 сая төгрөг болов
б) W	2) Байгууллагын түрээсийн орлого 25 сая төгрөг болов
в) G	3) Сүү ХК 80 сая төгрөгөөр үнээний ферм байгуулав
д) P	4) 200 хүүхдийн цэцэрлэгийг 70 сая төгрөгөөр барив
е) R	5) "Т" компанийн ашиг өмнөх сараас 25 сая төгрөгөөр өсөв

A. a3b1c4d5e2; орлого 60 сая зардал 175 сая төгрөг

B. a3b2c4d5e1; орлого 85 сая зардал 150 сая төгрөг

C. a3b1c5d4e2; орлого 60 сая зардал 175 сая төгрөг

D. a3b1c4d5e2; орлого 85 сая зардал 150 сая төгрөг

12. ДНБ-ий өсөлтийг онуудаар харуулж буй хүснэгтийг ажиглаад “Абсолют цэвэр өсөлт” болон “Өсөлтийн хурд”-ыг тооцоолоорой. /2 оноо/

Дараах томъёонуудаас сонгон бодолтыг хийгээрэй.

Y_n -Тухайн оны үзүүлэлт;

Y_{n-1} -Өмнөх оны үзүүлэлт

$$Y_n - Y_{n-1}; \quad \frac{Y_n}{Y_{n-1}}; \quad \frac{Y_n}{Y_{n-1}} \times 100\%; \quad \frac{Y_n}{Y_{n-1}} \times 100\% - 100\%;$$

Он	Үсгэн тэмдэглэгээ	ДНБ, тэрбум төгрөг	Абсолют цэвэр өсөлт	Өсөлтийн хурд /дахин/
2025	Y_{2025}	32,600,0	-	-
2026	Y_{2026}	34,400,0	a.....	b.....

A. a-1,800,0; b-10.5

C. a-1,800,0; b-105

B. a-105; b-1,800,0

D. a-1,800,0; b-1.05

Дараах тохиолдлыг уншаад 13-14 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Иргэн М нь цэцэрлэгийн эрхлэгч бөгөөд багшийн туслах ажилд авахаар нээлттэй ажлын байр зарлажээ. Тухайн зарыг төрийн албан хаагч иргэн Б (32 настай бөгөөд сүүлийн 16 сар нийгмийн даатгалын шимтгэлийг тасралтгүй төлсөн) хараад иргэн М буюу ажил олгогчтой уулзаж багшийн туслахаар ажиллах болсон. Харин ажил олгогч М нь ажилтан Б-тэй хөдөлмөрийн гэрээ байгуулалгүй ажлын чиг үүрэг өгсөн байна.

13. Цэцэрлэгийн эрхлэгч М нь ажилтан Б-с ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болох уу? /1 оноо/
- A. Иргэн Б нь багшийн туслах ажилтнаар ажилд орсон тул хөдөлмөрийн гэрээ байгуулах шаардлагагүй тул, ажил үүргээ гүйцэтгэж болно.
- B. Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй бол ажилтнаас ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болохгүй.
- C. Цэцэрлэгийн эрхлэгч М нь хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийг үндэслэн ажилтан Б-г багшийн туслах ажилтнаар ажиллуулж болно.
- D. Хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ч гэсэн ажилтнаас ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болно.
14. Хэрвээ иргэн Б нь жирэмсэн байсан бол жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг цалингийн хэдэн хувиар тооцон нийгмийн даатгалын сангаас авах ёстой вэ? /1 оноо/
- A. Сүүлийн 12 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцно.
- B. Сүүлийн 16 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцно.
- C. Сүүлийн 16 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцно.
- D. Сүүлийн 12 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцно.
15. Сахилгын шийтгэлд хамаарах жишээнүүдийг сонгоно уу? /2 оноо/

Сахилгын шийтгэл	1	Р байгууллагынхаа нууцыг задруулсан тул ажлаасаа чөлөөлөгдөв.
	2	М Сүхбаатарын талбай дээр танхайрсан тул баривчлагдав.
	3	П согтуугаараа машин жолоодсон тул жолоодох эрхээ хасуулав.
	4	Х зөрчил гаргасан тул үндсэн цалингийн 20 хувийг хасаж цалинг олгов.
	5	Ажилтан С ажлаа тасалсан тул сануулах арга хэмжээ авхуулав.

A. 1, 4, 5

B. 1, 3, 5

C. 2, 3, 4

D. 1, 2, 5

16. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.

/3 оноо/

а) Чадамж б) Иргэний эрх зүйн харилцааны объект в) Иргэний эрх зүйн харилцааны агуулга д) Иргэний эрх зүйн харилцааны субъект е) Чадвар	1	Эдийн баялаг болох эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, мөн эрх багтана.
	2	Иргэдийн хоорондын эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус амины шинжтэй харилцаа.
	3	Үйлдлээр эрх олж авах, үүрэг бий болгох, үүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг биечлэн хариуцах онцгой чадвар.
	4	Талуудын тэгш эрхийн үндсэн дээр тэдний эрх үүргээр тодорхойлогддог.
	5	Эрх эдэлж, үүрэг хүлээх ерөнхий ойлголт юм.
	6	Эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус амины харилцаанд оролцож, хуулиар олгогдсон эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа этгээд

A. a3b1c4d6e5

B. a3b1c4d6e2

C. a5b1c4d6e3

D. a5b1c4d6e2

17. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой.

/1 оноо/

Манай улс анхдугаар үндсэн хуулиа батлан гаргасан.

A. 1992 онд

B. 1990 онд

C. 1960 онд

D. 1924 онд

18. “Төлөөллийн ардчилал” гэсэн ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ?

/1 оноо/

A. Иргэдийн улс төрд оролцох идэвх, сонирхол өсдөг ардчиллын хэлбэр.

B. Олон түмэн өөрөө өөрийгөө удирдаж, иргэн бүрийг төрийн хэрэгт оролцуулдаг хэлбэр

C. Аливаа асуудлаар бүх иргэн саналаа илэрхийлэх боломжтой байдаг хэлбэр

D. Албан тушаалтныг сонгож, түүгээр дамжуулж засаглалыг хэрэгжүүлэх хэлбэр

19. 1990 оны дараах төрийн бодлогод аль нь хамаарах вэ?

/1оноо/

A. Хүний эрхийн түгээмэл зарчмуудыг бодитой хэрэгжүүлж эхэлсэн

B. Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд хэм хэмжээ тогтоох

C. Ардчилсан зарчмыг улс төр, үзэл суртлын компани болгож төлөвлөх

D. Нэг намын үзэл суртлыг үнэний дээд болгон тунхаглах

20. Монгол улсын төрийн эрх мэдлийн хуваарилалт нь УИХ, засгийн газар, шүүх гэсэн тогтолцоотой байдаг. Үүнээс засгийн газрын бүрдэл, бүтцийг зөв тодорхойлсон хэсгийг сонгоорой.

/2 оноо/

A. Ерөнхий сайдыг УИХ-ын гишүүд өргөн мэдүүлснээр УИХ томилно.

ЗГ-ын бусад гишүүдийг Ерөнхийлөгч өргөн мэдүүлснээр УИХ томилно.

ЗГ нь төрийн хууль биелүүлэх ажлыг хариуцаж, эрх зүйн хүрээнд захирамж гаргана.

B. Ерөнхий сайдыг УИХ-ын гишүүд өргөн мэдүүлснээр Ерөнхийлөгч томилно.

ЗГ-ын бусад гишүүдийг Ерөнхий сайд өргөн мэдүүлснээр УИХ томилно.

ЗГ нь төрийн хууль батлах ажлыг хариуцаж, эрх зүйн хүрээнд зарлиг, захирамж гаргана.

C. Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч өргөн мэдүүлснээр УИХ томилно.

ЗГ-ын бусад гишүүдийг Ерөнхий сайд өргөн мэдүүлснээр УИХ томилно.

ЗГ нь төрийн хууль биелүүлэх ажлыг хариуцаж, эрх зүйн хүрээнд тогтоол гаргана.

D. Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч өргөн мэдүүлснээр УИХ томилно.

ЗГ-ын бусад гишүүдийг Ерөнхийлөгч өргөн мэдүүлснээр УИХ томилно.

ЗГ нь төрийн хууль батлах ажлыг хариуцаж, эрх зүйн хүрээнд тушаал, захирамж гаргана.

21. Олон улсын харилцааны улс бус оролцогчдод аль нь хамаарахгүй вэ?

/1 оноо/

A. Нөлөө бүхий хувь хүн

C. Их гүрэн

B. Үндэстэн дамнасан корпорацууд

D. Террорист байгууллага

- 22.** Олон улсын харилцаанд оролцох нөлөө гэсэн ойлголтод аль хамаарч байна вэ? /1 оноо/
- A. Олон улсын харилцаанд улс төр, эрх зүй, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн гэсэн үйл ажиллагаагаар оролцдог.
 - B. Олон улсын олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллөөр тодорхойлогдоно.
 - C. МУ бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавх, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах, үнэлэх явдал.
 - D. Засгийн газрын оролцоо, дэмжлэггүйгээр байгуулагдсан, олон улсын байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хэлнэ.

- 23.** Дунд улсын тухай ойлголтыг аль хэсгийн, ямар дараалалд илэрхийлж байна вэ? /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Олон улсын харилцаанд нөлөө багатай	Хөрш болон бүс нутагтаа баттай нөлөөлдөг
2-р хэсэг	Дэлхийн улсуудын 66 хувийг эзэлдэг	Голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд

- A. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
- B. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А

- C. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
- D. 2-р хэсэг – А; 2-р хэсэг – Б